

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын эрүүл мэндийн төвийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан**

Аудитын код: ХӨА-2026/214/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум

2026 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунтуяа

Утас: 99036832 Цахим хаяг: ariuntuyab@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: Munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7036 3793. Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/172
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-УУЛ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Н.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 191,585.5 мянган төгрөгийг санхүүжилтийн авлагаар бүртгэсэн, төсөвт хасах тодотгол хийсний улмаас гэрэл, цахилгаан, түлш халаалтын зардалд 57,854.1 мянган төгрөгийн өр төлбөртэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар 68,479.2 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчлийг илрүүлж 68,404.6 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 74.6 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өглөө.

Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2025 оны гэрээний биелэлтийг 95.0 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	456,409,109.46	427,601,416.93
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,820,023.98	5,000,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,820,023.98	5,000,000.00
3121	Төгрөг	2,820,023.98	5,000,000.00
31211	Төрийн сангийн харилцах	2,820,023.98	5,000,000.00
33	АВЛАГА	253,025,904.52	240,923,677.26
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	188,150.39
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	253,025,904.52	191,585,475.87
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	49,150,051.00
35	БАРАА МАТЕРИАЛ	200,563,180.96	181,677,739.67
351	Түүхий эд материал	77,493,620.03	75,476,613.43
35130	Эм боох материал	77,493,620.03	75,476,613.43
354	Хангамжийн материал	123,069,560.93	106,201,126.24
35410	Бичиг хэргийн материал	6,502,300.00	8,028,150.00
35420	Аж ахуйн материал	82,993,991.41	85,904,886.51
35430	Сэлбэг хэрэгсэл	3,115,000.00	2,590,000.00
35440	Түлш, шатах тослох материал	4,891,880.00	6,258,640.00
35450	Барилгын засварын материал	19,267,750.00	1,413,950.00
35460	Хүнсний материал	6,298,639.52	2,005,499.73
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	754,434,302.42	887,285,115.68
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	754,434,302.42	887,285,115.68
392	Биет хөрөнгө	740,818,302.32	873,757,115.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	330,915,290.00	370,975,290.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-143,945,834.44	-169,589,840.34
39203	Авто-тээврийн хэрэгсэл	146,252,000.00	252,351,366.47
39204	Хуримтлагдсан элэгдэл	-42,552,555.44	-43,255,555.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	457,679,416.33	551,140,268.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	-122,705,264.42	-194,376,471.80
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	153,493,917.20	157,371,317.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-49,331,896.44	-60,493,424.28
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,015,800.00	15,015,800.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,002,570.47	-5,381,634.47
393	Биет бус хөрөнгө	13,616,000.10	13,528,000.14
39301	Програм хангамж	715,000.00	715,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-494,999.90	-582,999.86
39303	Бусад биет бус хөрөнгө	13,396,000.00	13,396,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,210,843,411.88	1,314,886,532.61
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	24,436,797.14	57,854,077.87
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	24,436,797.14	57,854,077.87
413	Өглөг	24,436,797.14	57,854,077.87
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	01.87	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	24,432,395.27	57,854,077.87
4136	Бусад өглөг	4,400.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	4,400.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,186,406,614.74	1,257,032,454.74
51	Засгийн газрын хувь оролцоо	1,186,406,614.74	1,257,032,454.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	226,654,626.00	226,654,626.00
51101	Өмч: - төрийн	226,654,626.00	226,654,626.00
512	Хуримтлагдсан үр дүн	724,921,997.55	795,547,837.55
51210	Өмнөх үеийн үр дүн	724,921,997.55	724,921,997.55

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	70,625,840.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	234,829,991.19	234,829,991.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,210,843,411.88</u>	<u>1,314,886,532.61</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,766,706,893.96	2,173,480,640.49
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	228,532,268.95	446,986,033.89
120	Нийтлэг татварын бус орлого	228,532,268.95	446,986,033.89
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	228,532,268.95	446,986,033.89
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,896,000.00	123,100,597.50
120017	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-үндсэн хөрөнгө	137,404,785.40	293,958,208.47
120018	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-бараа материал	44,231,483.55	29,927,227.92
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,538,174,625.01	1,726,494,606.60
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	83,862,000.00	66,828,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	83,862,000.00	66,828,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,454,312,625.01	1,659,665,706.60
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,454,312,625.01	1,659,665,706.60
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,466,648,148.54	2,043,814,800.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,466,648,148.54	2,043,814,800.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,421,752,048.08	1,950,036,749.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	965,581,100.87	1,182,981,608.74
210101	Үндсэн цалин	575,128,347.97	630,236,908.42
210102	Нэмэгдэл	322,214,888.53	419,640,429.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,387,667.48	28,564,779.05
210104	Урамшуулал	56,850,196.89	104,539,491.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,157,900.00	146,332,548.73
210201	Тэтгэврийн даатгал	70,827,400.00	103,557,335.08
210202	Тэтгэмжийн даатгал	8,332,600.00	11,074,161.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,166,300.00	6,875,389.77
210204	Ажилгүйдлийн даатгал	4,166,300.00	5,106,286.59
210205	Эрүүл мэндийн даатгал	16,665,300.00	19,719,376.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,601,610.21	97,434,219.81
210301	Гэрэл, цахилгаан	6,610,043.41	9,752,368.53
210302	Түлш, халаалт	83,591,566.80	87,125,850.00
210303	Цэвэр, бохир ус	1,400,000.00	556,001.28
2104	Хангамж, бараа материалын зардал	50,445,337.03	89,688,876.54
210401	Бичиг хэрэг	11,310,600.00	12,598,700.00
210402	Тээвэр, шатахуун	25,154,520.00	28,802,393.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,935,800.00	3,215,804.00
210404	Ном, хэвлэл	00.00	10,860,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	48,000.00	2,895,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,996,417.03	15,197,852.90
210408	Бараа материал акталсны зардал	00.00	16,118,526.64
2105	Нормативт зардал	119,392,724.52	164,756,862.46

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	99,357,466.93	125,989,513.67
210502	Хоол, хүнс	20,035,257.59	25,377,348.79
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	13,390,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,385,000.00	102,190,000.00
210604	Урсгал засвар	5,385,000.00	102,190,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,000,000.00	16,960,000.00
210702	Дотоод албан томилолт	8,000,000.00	16,960,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,413,502.06	12,235,238.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,107,364.06	5,595,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	2,304,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	183,450.00	182,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,500.00	209,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	35,000.00
210807	Газрын төлбөр	40,188.00	40,188.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	3,869,050.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,774,873.39	137,457,395.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,949,392.00	760,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,825,481.39	136,697,395.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,896,100.46	93,778,051.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,826,000.00	93,778,051.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	39,796,051.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	44,826,000.00	53,982,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	70,100.46	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	70,100.46	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	300,058,745.42	129,665,840.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	59,040,000.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө		59,040,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	(59,040,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	300,058,745.42	70,625,840.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,372,461,270.19	1,861,885,581.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	46,896,000.00	73,950,546.50
120	Нийтлэг татварын бус орлого	46,896,000.00	73,950,546.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,000.00	73,950,546.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	73,950,546.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,325,565,270.19	1,787,935,035.25
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	83,862,000.00	66,828,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	83,862,000.00	66,828,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,241,703,270.19	1,721,106,135.25
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,241,703,270.19	1,721,106,135.25
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,390,832,304.06	1,825,075,605.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,390,832,304.06	1,825,075,605.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,345,936,203.60	1,731,297,554.73

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	965,581,099.00	1,183,169,761.00
210101	Үндсэн цалин	575,128,346.10	630,425,060.68
210102	Нэмэгдэл	322,214,888.53	419,640,429.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,387,667.48	28,564,779.05
210104	Урамшуулал	56,850,196.89	104,539,491.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,157,900.00	146,332,548.73
210201	Тэтгэврийн даатгал	70,827,400.00	103,557,335.08
210202	Тэтгэмжийн даатгал	8,332,600.00	11,074,161.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,166,300.00	6,875,389.77
210204	Ажилгүйдлийн даатгал	4,166,300.00	5,106,286.59
210205	Эрүүл мэндийн даатгал	16,665,300.00	19,719,376.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,861,899.54	63,828,900.00
210301	Гэрэл, цахилгаан	6,610,043.41	9,067,889.46
210302	Түлш, халаалт	72,851,856.13	54,205,009.26
210303	Цэвэр, бохир ус	1,400,000.00	556,001.28
2104	Хангамж, бараа материалын зардал	45,076,099.00	77,086,157.00
210401	Бичиг хэрэг	2,307,200.00	4,308,700.00
210402	Тээвэр, шатахуун	28,833,000.00	30,169,153.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,935,800.00	3,215,804.00
210404	Ном, хэвлэл	00.00	19,585,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,000,000.00	5,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,000,099.00	14,807,500.00
2105	Нормативт зардал	109,488,312.00	129,251,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	88,488,312.00	96,136,553.79
210502	Хоол, хүнс	15,000,000.00	18,165,746.21
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,000,000.00	14,949,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,000,000.00	88,811,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	12,000,000.00	83,811,200.00
2107	Томилолт, зочны зардал	8,000,000.00	16,960,000.00
210702	Дотоод албан томилолт	8,000,000.00	16,960,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,821,502.06	10,857,688.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,107,364.06	5,595,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	2,304,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	183,450.00	182,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,500.00	209,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	35,000.00
210807	Газрын төлбөр	40,188.00	40,188.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,408,000.00	2,491,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,949,392.00	15,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,949,392.00	15,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,896,100.46	93,778,051.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,826,000.00	93,778,051.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	39,796,051.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	44,826,000.00	53,982,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	70,100.46	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	70,100.46	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-18,371,033.87	36,809,976.02
		00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	19,000,000.00	34,630,000.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,000,000.00	34,630,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,000,000.00	34,630,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,000,000.00	34,630,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-19,000,000.00	-34,630,000.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-37,371,033.87	2,179,976.02
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	40,191,057.85	2,820,023.98
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,820,023.98	5,000,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	226,654,626.00	238,484,708.82	-1,013,903.96	464,125,430.86
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-7,959,062.58	-7,959,062.58
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	226,654,626.00	234,829,991.19	724,921,997.55	1,186,406,614.74
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	226,654,626.00	234,829,991.19	724,921,997.55	1,186,406,614.74
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	70,625,840.00	70,625,840.00
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	226,654,626.00	234,829,991.19	795,547,837.55	1,257,032,454.74

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан Улсын төсвийн гүйцэтгэл

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	төгрөгөөр	
				зөрүү	хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,106,964,900.00	1,795,056,681.75	311,908,218.25	85.2
12	Татварын бус орлого	2,106,964,900.00	1,795,056,681.75	311,908,218.25	85.2
120	Нийтлэг татварын бус орлого	130,785,500.00	73,950,546.50	56,834,953.50	56.5
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	130,785,500.00	73,950,546.50	56,834,953.50	56.5
122	Тусламжийн орлого	1,976,179,400.00	1,721,106,135.25	255,073,264.75	87.1
122001	Хандив тусламж /дотоод/	1,976,179,400.00	1,721,106,135.25	255,073,264.75	87.1
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,109,741,200.00	1,792,876,705.73	316,864,494.27	85.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,109,741,200.00	1,792,876,705.73	316,864,494.27	85.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,109,741,200.00	1,792,876,705.73	316,864,494.27	85.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,438,396,800.00	1,183,169,761.00	255,227,039.00	82.3
210101	Үндсэн цалин	709,541,700.00	630,425,060.68	79,116,639.32	88.8
210102	Нэмэгдэл	548,705,800.00	419,640,429.51	129,065,370.49	76.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	54,203,800.00	28,564,779.05	25,639,020.95	52.7

210104	Урамшуулал	125,945,500.00	104,539,491.76	21,406,008.24	83.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	191,573,700.00	146,332,548.73	45,241,151.27	76.4
210201	Тэтгэврийн даатгал	133,845,600.00	103,557,335.08	30,288,264.92	77.4
210202	Тэтгэмжийн даатгал	14,432,100.00	11,074,161.21	3,357,938.79	76.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,216,000.00	6,875,389.77	340,610.23	95.3
210204	Ажилгүйдлийн даатгал	7,216,000.00	5,106,286.59	2,109,713.41	70.8
210205	Эрүүл мэндийн даатгал	28,864,000.00	19,719,376.08	9,144,623.92	68.3
2104	Хангамж, бараа материалын зардал	79,467,300.00	77,086,157.00	2,381,143.00	97.0
210401	Бичиг хэрэг	4,308,700.00	4,308,700.00	00.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	32,250,000.00	30,169,153.00	2,080,847.00	93.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,516,100.00	3,215,804.00	300,296.00	91.5
210404	Ном, хэвлэл	19,500,900.00	19,585,000.00	-84,100.00	100.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,000,000.00	5,000,000.00	00.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,891,600.00	14,807,500.00	84,100.00	99.4
2105	Нормативт зардал	129,751,300.00	129,251,300.00	500,000.00	99.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	98,938,000.00	96,136,553.79	2,801,446.21	97.2
210502	Хоол, хүнс	15,813,300.00	18,165,746.21	-2,352,446.21	114.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,000,000.00	14,949,000.00	51,000.00	99.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	120,811,200.00	120,441,200.00	370,000.00	99.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,000,000.00	25,000,000.00	00.00	100.0
210602	Тавилга	10,000,000.00	9,630,000.00	370,000.00	96.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,000,000.00	5,000,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	80,811,200.00	80,811,200.00	00.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	17,000,000.00	16,960,000.00	40,000.00	99.8
210702	Дотоод албан томилолт	17,000,000.00	16,960,000.00	40,000.00	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,102,900.00	10,857,688.00	245,212.00	97.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,595,500.00	5,595,500.00	00.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,304,000.00	2,304,000.00	00.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	246,000.00	182,000.00	64,000.00	74.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	209,500.00	209,500.00	00.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	216,000.00	35,000.00	181,000.00	16.2
210807	Газрын төлбөр	40,400.00	40,188.00	212.00	99.5
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,491,500.00	2,491,500.00	00.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20000000.00	15000000.00	5,000,000.00	75.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,000,000.00	15,000,000.00	5,000,000.00	75.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	101,638,000.00	93,778,051.00	7,859,949.00	92.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	101,638,000.00	93,778,051.00	7,859,949.00	92.3

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,188,000.00	39,796,051.00	7,391,949.00	84.3
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	54,450,000.00	53,982,000.00	-	-
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(2,776,300.00)	2,179,976.02	-	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,776,300.00	(2,179,976.02)	-	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	2,776,300.00	(2,179,976.02)	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	2,820,023.98		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	5,000,000.00		

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	66,828,900.00	66,828,900.00	-	100.0
12	Татварын бус орлого	66,828,900.00	66,828,900.00	-	100.0
122	Тусламжийн орлого	66,828,900.00	66,828,900.00	-	100.0
122005	Төсвөөс санхүүжих	66,828,900.00	66,828,900.00	-	100.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	66,828,900.00	66,828,900.00	-	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	66,828,900.00	66,828,900.00	-	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	66,828,900.00	66,828,900.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,828,900.00	63,828,900.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	7,278,600.00	9,067,889.46	(1,789,289.46)	124.6
210302	Түлш, халаалт	55,110,300.00	54,205,009.26	905,290.74	98.4
210303	Цэвэр, бохир ус	1,440,000.00	556,001.28	883,998.72	38.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 68,479.2 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчлийг илрүүлснээс 68,404.6 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 74.6 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгч, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлага хүргүүллээ.

3.1 Залруулсан алдаа

1. Тус эрүүл мэндийн төв нь 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэж ирүүлэхдээ тайлант жилийн худалдан авах ажиллагааны тайланг бэлтгэж ирүүлээгүй, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтын дагуу бэлтгээгүй нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.3 “тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл;” заалттай нийцэхгүй байх тул аудитын явцад нөхөн гаргасан.
2. Аймгийн Эрүүл мэндийн газраас олгох төрийн албан хаагчийн тэтгэвэрт гарах тэтгэмж болон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн санхүүжилт 49,150.1 мянган төгрөгөөр дутуу орж ирсэн байхад ажилтнуудад олгож, ЭМДС-ийн санхүүжилтээс зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6 “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх.” заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аймгийн Эрүүл мэндийн газраас авах санхүүжилтийн авлагаар залруулан бүртгүүлсэн.
3. Ажлын хөлс, тээврийн хөлс 7,749.5 мянган төгрөгийг бараа материалын дансанд орлогод авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.1 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул залруулж, тайлант үеийн зардлаар бүртгүүлж, залруулсан.
4. Байгууллагын үйл ажиллагаанд нэгээс дээш жил ашиглагдах 10,025.7 мянган төгрөгийн хангамжийн материалыг эзэмшигчид нь карталж хариуцуулаагүй, шууд тайлант үеийн зарлагаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулж бүртгэсэн.
5. Тайлант онд шинээр орлогод бүртгэсэн үндсэн хөрөнгийн элэгдлийг байгуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул 1,479.3 мянган төгрөгийн элэгдлийг нөхөж байгуулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 74.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 23,466.4 мянган төгрөгөөс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.2. Албан шаардлага

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны шилэн дансны мэдээллийг www.shilendans.gov.mn цахим хуудаснаас шалгахад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил илэрсэн нь өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 заалтад “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;” гэж заасантай нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлсэн. .

3.3. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төлбөртэй үйлчилгээний орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус эрүүл мэндийн төв нь үйлчлүүлэгчид үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, жагсаалтыг гаргаж батлаагүй, шүдний эмчилгээний төлбөрийн орлогыг төвлөрүүлээгүй байгаа нь Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт нь улсын төсөв, эрүүл мэндийн даатгал, Засгийн газрын тусгай сан болон аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэний хандив, эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй тусламж, үйлчилгээ, бусад үйл ажиллагааны орлого, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.”, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Жагсаалт, журам батлах тухай” А/216 дугаар тушаал, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 49/А/118 тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам”-тай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хууль журамд нийцүүлэн төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалт, төлбөрийн хэмжээг баталж мөрдөх

2. Татвар, төлбөр, хураамжтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Автотээврийн хэрэгслийн 74.6 мянган төгрөгийн татварыг нөхөн төлсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татвар, төлбөр хураамжийг тухай бүрд нь төлж байх, улсын бүртгэлээс хасагдаагүй байгаа тээврийн хэрэгслийг хасуулах

3. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн “тэг” үлдэгдэлтэй 61 нэр төрлийн 129,563.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;” заалт болон ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар бүлгийн 7.1 заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тэг үлдэгдэлтэй хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнэлгээг шинэчлэн бүртгэлд тусгах

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруу лаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланд худалдан авах ажиллагааны тайланг хавсаргаагүй.	1	-	1	-			1	-		
Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвортой ажилласны тэтгэмжийг санхүүжилт нь орж ирээгүй байхад ЭМДС-ын санхүүжилтээс олгосон	1	49,150.1	1	49,150.1			1	49,150.1		
Ажлын хөлс, тээврийн хөлсийг бараа материалын дансанд орлого авсан.	1	7,749.5			1	7,749.5	1	7,749.5		
Ашиглалтад тавьж олгосон хангамжийн материалыг тайлант үеийн зардлаар бүртгэсэн.	1	10,025.7			1	10,025.7	1	10,025.7		
Үндсэн хөрөнгийн элэгдлийг дутуу тооцож бүртгэсэн.	1	1,479.3	1	1,479.3			1	1,479.3		
Дүн	5	68,404.6	3	50,629.4	2	17,775.2	5	68,404.6		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Автотээврийн хэрэгслийн татварыг нөхөн төлсөн	1	74.6					1	74.6
Эмнэлгийн төлбөртэй тусламж үйлчилгээний жагсаалт, төлбөрийн хэмжээг баталж мөрдөөгүй, шүдний орлого төвлөрүүлээгүй.	1	-					1	-
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн "0" үлдэгдэлтэй хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнэлгээг шинэчлээгүй	1	-					1	-
Дүн	3	74.6					3	74.6

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, өмнөх аудитын зөвлөмж хэрэгжүүлээгүй	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			